



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/1257

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны Е/05 дугаар албан бичгээр өгөгдсөн чиглэл, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2023 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” хот байгуулалтын баримт бичиг, Засгийн газрын 2021 оны 282 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 121 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энэ захирамжийн хавсралтад заасан нийт 13,763,126,958.00 (арван гурван тэрбум долоон зуун жаран гурван сая нэг зуун хорин зургаан мянга есөн зуун тавин найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг Нийслэлийн өмчөөс төрийн өмч /Улсын дээд шүүх/-д шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар), Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар (Н.Баттулга)-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205557

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 11 сарын 07 өдрийн
 захирамжийн
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Шилжүүлэх байгууллагын нэр	Дансны нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Биет бус хөрөнгө	589.00	19,072,820.00	19,072,820.00		19,072,820.00
		Машин, тоног төхөөрөмж	7.00	31,415,000.00	46,930,000.00	46,930,000.00	-
		Тавилга, эд хогшил	1.00	19,000,000.00	19,000,000.00	19,000,000.00	-
		Бусад	14.00	12,933,000.00	14,748,000.00	14,748,000.00	-
		Нийт дүн	611.00	82,420,820.00	99,750,820.00	80,678,000.00	19,072,820.00
2	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар	Барилга байгууламж	10,582.00	1,269,208.63	13,430,765,686.00	881,487,100.60	12,549,278,585.40
		Машин, тоног төхөөрөмж	186.00	49,251,229.00	108,633,829.00	45,514,925.98	63,118,903.02
		Тавилга, эд хогшил	161.00	4,761,165.00	29,089,665.00	21,389,519.50	7,700,145.50
		Бусад	4.00	8,307,228.00	8,307,228.00	5,623,242.83	2,683,985.17
		Биет бус хөрөнгө	1.00	16,800,000.00	16,800,000.00	9,333,333.40	7,466,666.60
		Хангамжийн материал	155.62	48,829,710.00	59,990,130.00	-	59,990,130.00
		Нийт дүн	11,089.62	129,218,540.63	13,653,586,538.00	963,348,122.31	12,690,238,415.69
3	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Машин, тоног төхөөрөмж	4.00	2,447,400.00	9,789,600.00	9,789,600.00	-
	Нийт шилжүүлэх дүн		11,704.62	214,086,760.63	13,763,126,958.00	1,053,815,722.31	12,709,311,235.69